



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/101

Баянхутаг сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”- ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, “Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.1.1 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 18 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшигч байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх, газрыг зориулалтын дагуу эзэмшиж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамлын түр орлон гүйцэтгэгч / Т.Наранбаяр/-т үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээний дагуу эзэмшихийг газар эзэмшигч байгууллагуудад даалгасугай.

ДАРГА



Б.АМГАЛАНБАТ

Ин Засаг даргын 2024 о
арын /.../ өдрийн то
жийн /.../ дүгээр хавсра

Д/д	Төрийн байгууллагын оноосон нэр	Регистрийн дугаар	Төлөвлөлтийн нэгж талбар	Газрын зориулалт	Байршил	Газрын хэмжээ /га/	Газар эзэмших хугацаа /жил/
1	Баянхутаг сумын Засаг даргын тамгын газар	9074449	3780835	2407: Хогийн цэг	Сумын төвийн баруун урд	6.5706	15
2	Баянхутаг сумын Засаг даргын тамгын газар	9074449	3864751	2122: Нийтийн үйлчилгээний байгууллага	Хаялагат	2	15
3	Хэнтий аймгийн Шүүхийн тамгийн газарт	9074538	3789295	2101: Төрийн захиргааны байгууллага	Хаялагат	0.2	15
4	Баянхутаг сумын Засаг даргын тамгын газар	9074449	3782991	2101: Төрийн захиргааны байгууллага	Баянхүрээ уул	0.3	15
2 байгууллага 4 байршилд						9.0706 га	